

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (цаашид “МХБ” гэх)-ийн гишүүн үнэт цаасны компани (цаашид “Гишүүн ҮЦК” гэх)-ийн ажилтанд МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх (цаашид “Арилжаанд оролцох эрх” гэх) олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам болон МХБ-ийн эрх бүхий албан тушаалтнаас баталсан журам, заавар, гишүүн ҮЦК-тай байгуулсан гэрээтэй уялдсан байна.

1.3. Энэхүү журмыг арилжаанд оролцох эрх авахаар хүсэлт гаргасан болон тус эрхийг авсан гишүүн ҮЦК-ийн ажилтан дагаж мөрдөнө.

Хоёр. Арилжаанд оролцох эрх олгох

2.1. Гишүүн ҮЦК-ийн ажилтанд арилжаанд оролцох эрх олгоход тавигдах ерөнхий шаардлага. Үүнд:

2.1.1. СЗХ-ноос “Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны зуучлалын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх”-ийн үнэмлэхийн хугацаа хүчинтэй байх.

2.1.2. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллагад 3 ба түүнээс дээш сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааг хариуцан ажиллаж дадлагажсан байх;

2.1.3. Сүүлийн 6 сарын дотор журмын 3.1, 3.3-д заасан арга хэмжээ авагдаагүй байх;

2.1.4. Ажилтан нь гишүүн ҮЦК-ийн захирал, брокер, дилерийн аль нэг албан тушаалд томилогдсон байх;

2.1.5. МХБ-ийн Арилжааны журам, Трейдэр программ болон арилжаа зохион байгуулахтай холбоотой журам, заавартай танилцсан байх ба шаардлагатай тохиолдолд МХБ-ээс Трейдер программын талаар зохих зааварчилгааг авч болно;

2.2. Гишүүн ҮЦК-ийн ажилтны арилжаанд оролцох эрхийг сунгах, шинээр олгоход бүрдүүлэх материал. Үүнд:

2.2.1. Гишүүн ҮЦК-иас өөрийн ажилтанд арилжаанд оролцох эрх олгохыг хүссэн албан бичиг;

2.2.2. Журмын 2.1-т заасан шаардлагыг бүрэн хангасан болохыг нотлох баримт;

2.2.3. 3х4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;

2.2.4. Үйлчилгээний хөлс 20,000.0 /хорин мянган/ төгрөг төлсөн баримт. Уг хөлсийг хүсэлт гаргахдаа буцаан олгогдохгүй нөхцөлтэйгөөр төлнө;

2.3. Арилжаанд оролцох эрх авахаар ирүүлсэн материалыг хянан шийдвэрлэх.

2.3.1. Журмын 2.1-д заасан шаардлага, журмын 2.2-т заасан материалын бүрдлийг бүрэн хангасан Гишүүн ҮЦК-ийн ажилтанд МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр арилжаанд оролцох эрх олгоно.

2.3.2. МХБ-ийн "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх"-ийн хугацаа нь СЗХ-ноос олгосон "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх"-ийн хугацаатай ижил байна.

2.3.3. Гүйцэтгэх захирлын шийдвэрийг үндэслэн холбогдох алба, нэгж нь арилжаанд оролцох эрхийн нэр, нууц үгийг сэргээх эсхүл шинээр олгоно.

2.3.4. МХБ-д ирүүлсэн материал бүрэн бус, шаардлага хангаагүй тохиолдолд арилжаанд оролцох эрх олгохоос татгалзана.

2.3.5. Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлахтай холбоотой бүртгэл, хяналтыг МХБ-ийн холбогдох алба, нэгж хэрэгжүүлнэ.

Гурав. Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах

3.1. МХБ-ээс дараах үндэслэлээр гишүүн ҮЦК-ийн ажилтны арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлнэ. Үүнд:

3.1.1. СЗХ-ноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлсэн;

3.1.2. СЗХ-ноос олгосон "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх"-ийн хугацаа дууссан эсхүл хүчингүй болсон;

3.1.3. МХБ-ийн Гишүүнчлэлийн журам, ёс зүйн дүрэм, журам болон МХБ-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн;

3.1.4. МХБ-ийн "Хяналт шалгалтын журам"-ын 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтад заасан зөрчил гаргасан;

3.1.5. Арилжааны трейдэр программ хангамжид нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулах, зориулалтын бусаар ашиглах боломжийг санаатай болон болгоомжгүй байдлаар олгосон;

3.1.6. Арилжааны программ хангамж болон харилцагчийн үнэт цаасны данстай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг бусдад задруулсан;

3.1.7. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 6 ба түүнээс дээш сар эсхүл арилжаанд оролцох эрх авснаас хойш 3 ба түүнээс дээш сарын хугацаанд үнэт цаасны зах зээлд ажиллаагүй;

3.2. Арилжаанд оролцох эрхийг дараах тохиолдолд сэргээнэ. Үүнд:

3.2.1. Эрх бүхий этгээдээс үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхийг сунгасан эсхүл сэргээсэн;

3.2.2. Энэхүү журмын 3.1.3-3.1.7-д заасан арга хэмжээ авагдсан тохиолдолд гаргасан зөрчлийг арилгуулахаар МХБ-ээс өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлсэн;

3.2.3. Арилжаанд оролцох эрх нь түдгэлзсэн ажилтны гаргасан зөрчлийг бүрэн арилгасан тухай ажил олгогч гишүүн ҮЦК-иас МХБ-д мэдэгдсэн эсхүл зөрчил арилсан гэж МХБ-ээс тогтоосон;

3.2.4. МХБ-ийн ТУЗ эсхүл зохицуулах эрх бүхий байгууллага, шүүх хяналтын байгууллагаас гишүүн ҮЦК-ийн ажилтанд авсан арга хэмжээг үндэслэлгүй гэж тогтоосон;

3.2.5. Хууль тогтоомж, дүрэм, журамд заасан бусад үндэслэл;

3.3. МХБ-ээс дараах тохиолдолд гишүүн ҮЦК-ийн ажилтны арилжаанд оролцох эрхийг цуцална. Үүнд:

3.3.1. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, заавар ноцтой зөрчсөн нь СЗХ болон шүүхээр тогтоогдсон;

3.3.2. Монгол улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", СЗХ болон МХБ-ийн холбогдох журам, "Гишүүний ёс зүйн дүрэм", МХБ-тэй байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г удаа дараа ноцтой зөрчсөн тухай МХБ-ийн дүгнэлт гарсан;

3.3.3. Ажилтан өөрөө болон ажил олгогч гишүүн ҮЦК-иас ажилтны эрхийг цуцлах тухай үндэслэл бүхий хүсэлт ирүүлсэн;

3.3.4. Энэхүү журмын 3.2.3-д заасан хүсэлтийг 3 сарын дотор МХБ-д гаргаагүй;

3.4. Журмын 3 дугаар зүйлийн 3.3-д заасан үндэслэлээр гишүүн ҮЦК-ийн ажилтны арилжаанд оролцох эрхийг цуцалснаас хойш тухайн ажилтанд 6 сарын дотор дахин тус эрхийг олгохгүй.

3.5. Журмын 3.4-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд арилжаанд оролцох эрхийг дахин олгохдоо журмын 2.3 дахь заалтыг баримтална.

3.6. Энэхүү журмын 3.1, 3.3-т заасан хариуцлагын арга хэмжээг хариуцсан алба, нэгжийн саналыг үндэслэн МХБ-ийн Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гишүүн ҮЦК-ийн ажилтан нь арилжаанд оролцох эрх олгох шийдвэртэй санал нийлэхгүй бол энэ тухай гомдлоо ажлын 5 хоногийн дотор МХБ-ийн ТУЗ-д гаргаж болно.

-----oOo-----

Хянасан:

Арилжаа, хяналтын
албаны захирал

М.Энхтуяа

Хуульч

Б.Баярцэцэг

Боловсруулсан:

АХА-ны мэргэжилтэн

Д.Өлзийбат

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 1/4891 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 209 тоот тушаалаар батлагдсан “МХБ-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрх авах мэргэжилтэнд тавих нөхцөл”-ийг хүчингүй болгосугай.
2. “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
3. Боловсон хүчний мэдлэг, ур чадвараас үүсэн гарах аливаа эрсдэл болон бусад үр дагаврыг хууль, журмын дагуу хариуцан ажиллахыг гишүүн үнэт цаасны компаниудад даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.АНГАР

Хянасан:

Арилжаа, хяналтын
албаны захирал

М.Энхтуяа

Боловсруулсан:

АХА-ны мэргэжилтэн

Д.Өлзийбат